

## ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

**Товч удирдамж:** Нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн доор /ард/ хариултаа үнэн зөв бичнэ. Компьютерын программ ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралт мөн Word-ын файлыг цахим шуудангаар тус тус Байнгын хороонд явуулна.

### НЭГ. НЭР ДЭВШИГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, НИЙТЛЭГ ШААРДЛАГА

Д/Д	Шалгуур үзүүлэлт
1.1	<b>Эцэг/эхийн нэр:</b> . Лхагважав. .... <b>Нэр:</b> . Гангэрэл. ....
1.2	<b>Нэр дэвших тухай хүсэлт гаргаж буй албан тушаал</b> УИХ-ын Төсвийн байнгын хорооны дэргэдэх Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд. ....
1.3	<b>Иргэний харьяалал</b> Монгол Улсын иргэн мөн эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих/. <b>Тийм</b> Монгол Улсаас өөр улсын иргэний харьяалалтай байсан эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих/. .....
1.4	<b>Хуулиар тусгайлан заасан шаардлагыг хангаж байгаа эсэх:</b> -эдийн засаг, санхүүгийн чиглэлээр магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх; <b>Тийм.</b> ..... ... -сүүлийн зургаан жилийн хугацаанд улс төрийн намын гишүүнчлэлгүй, улс төрийн үйл ажиллагаа явуулаагүй байх; <b>Тийм.</b> ..... ... -зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хугацаа хэтэрсэн өргүй байх; <b>Тийм.</b> ..... ... -хувь хүний ёс зүй болон нэр хүнд нь Зөвлөлийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байх; <b>Тийм.</b> ..... ... -эдийн засаг, санхүүгийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж, олон улсад нэр хүнд бүхий эрдэм, шинжилгээ судалгааны сэтгүүлд нийтлүүлсэн байх, эсхүл эдийн засаг, төсөв, мөнгөний бодлого, санхүү, татварын чиглэлээр мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх. Үүнд дараах мэдээллийг бичнэ. <ul style="list-style-type: none"><li>• албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа (эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно);</li><li>• удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл;</li><li>• хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл.</li><li>• эдийн засаг, санхүүгийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж, олон улсад нэр хүнд бүхий эрдэм, шинжилгээ судалгааны сэтгүүлд нийтлүүлснийг нотлох баримт бичиг, нийтлэлийн хуулбар.</li></ul>

	<ul style="list-style-type: none"> <li>Албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа (эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно);</li> </ul> <ol style="list-style-type: none"> <li>1. Үйл ажиллагааны газрын захирал, Төрийн банк, 2018-2022. ....</li> <li>2. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга, Монголбанк, 2016-2018</li> <li>3. Сангийн сайдын зөвлөх, Сангийн яам, 2012. ....</li> <li>4. Дотоод аудитын газрын захирал, Зоос банк, 2008-2009. ....</li> <li>5. Банк хянан шалгагч, Монголбанк, 1999-2008. ....</li> </ol>
1.5	<p><b>Мэргэжлийн өндөр мэдлэг, чадвар</b> Хүсэлт гаргагчийг эдийн засаг, төсөв, мөнгөний бодлого, санхүү, татварын чиглэлээр өндөр мэдлэг, ур чадвартайг нотлох онцлох 10 үйл ажиллагааг жагсаан (хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар) бичнэ. Үүнд дараах мэдээллийг бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>-үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа;</li> <li>-үйл ажиллагааны гол агуулга;</li> <li>-үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ;</li> <li>-үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл;</li> </ul> <p>Дээрхи 10 үйл явдлыг хүснэгтэнд жагсаалтаар (хавсралт 1) харуулав.</p>
1.6	<p><b>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар</b> Эдийн засаг, төсөв, мөнгөний бодлого, санхүү, татвар гэх мэт чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг холбоо, байгууллагад гишүүн бол нэрлэн бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>-Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүн болсон огноог бичнэ.</li> <li>-Мэргэжлийн холбоо, байгууллагад эрхэлж байгаа албан тушаалын нэр, огноог бичнэ.</li> </ul> <p><b>N/A</b>.....</p> <p>..</p> <p>.....</p> <p>.....</p>
1.7	<p><b>Хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл</b> -Өөрийн боловсруулсан, хянасан судалгааны ажил, ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>-Миний бие ЗГ-аас УИХ-д 2015 оны төсвийн төсөл өргөн баригдсаны дараагаар Нээлттэй Нийгэм форумын санал болгосноор ЗГ-ын гадаад өр, түүний дунд хугацааны хэтийн чиг хандлагын талаар судалгаа хийж олон нийтэд танилцуулсан, мөн энэ судалгааны үр дүнг хэд хэдэн ТВ нэвтрүүлгээр орж ярьсан.</li> </ul> <p>Судалгааны гарчиг: Монгол улсын ЗГ-ын гадаад өр Хэвлэсэн газар: Нээлттэй Нийгэм форум Цахим хуудас: <a href="http://www.forum.mn">www.forum.mn</a> Цахим шуудан: <a href="mailto:osf@forum.mn">osf@forum.mn</a> Огноо: 2014 он</p> <ul style="list-style-type: none"> <li>-Улирал тутам хэвлэгдэн гардаг “Mongolian Economy” сэтгүүлд доорх өгүүлүүдийг нийтлүүлсэн. Үүнд:</li> </ul> <p>Өгүүллийн гарчиг: Банкны салбараар дамжуулан гадаад хөрөнгийн урсгал татах боломжууд Хэвлэсэн газар: Mongolian Economy сэтгүүл Огноо: 5 сар 2015 он</p> <p>Өгүүллийн гарчиг: Өрийн удирдлагын тухай хууль болон түүний эргэн тойронд Хэвлэсэн газар: Mongolian Economy сэтгүүл Огноо: 3 сар 2015 он</p> <ul style="list-style-type: none"> <li>-Үндэсний баялгийн санг Монголд байгуулах боломжийн талаар судалгаа хийж судалгааны товч хураангуйг эдийн засаг, улс төр, бизнесийн чиглэлээр нийтлэл гаргадаг гадаадын цахим сайтад нийтлүүлсэн.</li> </ul> <p>Судалгааны нэр: Feasibility study for establishing SWF in Mongolia</p>

Нийтэлсэн цахим хуудасны линк:

<https://bootheglobalperspectives.com/page?id=1373820260WBG117435235&t=sovereign-wealth-fund-for-mongolia>

Огноо: 1 сар 2009 он

-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.

Харьяалагдаж байсан байгууллага: Монголбанк

Хэвлэсэн байгууллагын нэр: Монголбанк

Хэвлэсэн сэтгүүл: Монголбанкны эрхлэн гаргадаг “Мөнгө.Санхүү.Баялаг” сэтгүүл

Судалгааны гарчиг: Монгол улсын санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүд, тогтолцооны эрсдлийн шинжилгээ

Огноо: 2017 он

Гол агуулга: Судалгаагаар Монгол улсын санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтийг олон улсын аргачлалыг ашиглан тогтоож, санхүүгийн халалт эрсдлийн зураглалыг байгуулж, эрсдлийн ерөнхий чиг хандлагыг тодорхойлсон.

-сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ.

Илтгэл зохион байгуулсан байгууллага: ШУТИС-ын харъяа Бизнес, Менежментийн сургууль  
Хэлэлцүүлсэн илтгэл: Монголын банк санхүүгийн системд гарч буй томоохон өөрчлөлтүүд  
Ярианы огноо: 2021 он

Товч утга: Банкны тухай хуульд орсон өөрчлөлттэй холбоотойгоор Монгол улсын банк санхүүгийн системд гарч буй томоохон өөрчлөлтүүдийн талаар жишээ баримттайгаар илтгэсэн

Илтгэл зохион байгуулсан байгууллага: Туркт төгсөгч Монгол оюутнуудын холбоо

Хэлэлцүүлсэн илтгэл: Монгол улсын 2023 оны макро эдийн засгийн төлөв—Төсөв ба мөнгөний бодлого

Ярианы огноо: 2022 он

Товч утга: Монгол улсын 2023 оны төсөв ба мөнгөний бодлого батлагдсантай холбогдуулан төсөв ба мөнгөний бодлого хэрхэн батлагдав, түүний голлох заалтууд түүнчлэн энэхүү төсөв ба мөнгөний бодлого нь бизнес эрхлэгч жижиг дунд аж ахуй эрхлэгч нарт хэрхэн нөлөөлөх талаар яриа танилцуулга хийсэн

-сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө.

ТВ Ярилцлага: Bloomberg TV

Ярилцлагын сэдэв: Төсвийн алдагдлыг бууруулах талаар

Дүрс бичлэгийн линк: <https://www.youtube.com/watch?v=FogoNMSIKP0>

ТВ Ярилцлага: Монгол ТВ

Ярилцлагын сэдэв: ЗГ-ын гадаад болон дотоод өрийн талаар

Дүрс бичлэгийн линк: <https://youtu.be/05h5QVd6MAU?si=RoUanxTyiwqq9E-K>

ТВ Ярилцлага: Монгол ТВ

Ярилцлагын сэдэв: ЗГ-ын гадаад болон дотоод өрийн талаар

Дүрс бичлэгийн линк: <https://youtu.be/2hlcA-iuXD?si=Z6NKvS79zyyNx8rR>

ТВ Ярилцлага: Эх орон ТВ

	<p>Ярилцлагын сэдэв: Гадаад өрийн талаар Дүрс бичлэгийн линк: <a href="https://youtu.be/p9IH2coXK7s?si=Ej1VapR3glzILp8M">https://youtu.be/p9IH2coXK7s?si=Ej1VapR3glzILp8M</a></p> <p>Доорхи материалуудыг энэхүү хүсэлттэй хамт хавсаргасан болно.</p> <p>Хавсралтуудын жагсаалт: Илтгэлүүд: Хавсралт №2 Монгол улсын 2023 оны макро эдийн засгийн төлөв—Төсөв ба мөнгөний бодлого Хавсралт №3 Банкны тухай хуульд орсон өөрчлөлттэй холбоотойгоор Монгол улсын банк санхүүгийн системд гарч буй томоохон өөрчлөлтүүд</p> <p>Өгүүллүүд: Хавсралт №4 Банкны салбараар дамжуулан гадаад хөрөнгийн урсгал татах боломжууд, Mongolian Economy сэтгүүл Хавсралт №5 Өрийн удирдлагын тухай хууль болон түүний эргэн тойронд, Mongolian Economy сэтгүүл</p> <p>Судалгааны ажлууд: Хавсралт №6 Feasibility study for establishing SWF in Mongolia Хавсралт №7 Монгол улсын ЗГ-ын гадаад өр, Нээлттэй нийгэм форум Хавсралт №8 Монгол улсын санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүд, тогтолцооны эрсдлийн шинжилгээ, Монголбанкны эрхлэн гаргадаг “Мөнгө.Санхүү.Баялаг” сэтгүүл Хавсралт №9 Мэргэжлийн чиглэлээр гадаадад төрөл бүрийн сургалт, семинарт хамрагдсан тухай сертификатууд</p> <p><b>Жич:</b> Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх линкийг тусгана.</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
1.8	<p><b>Эрүүгийн хариуцлага</b> Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх /тийм, эсхүл үгүй гэж бичих, тийм гэж хариулсан бол холбогдох баримт бичгийн хуулбарыг хавсаргах/: <b>Үгүй</b></p> <p>.....</p> <p>.....</p>
1.9	<p><b>Сахилгын шийтгэлийн талаар</b> Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж эсхүл огцорч байсан эсэх <b>Үгүй</b></p> <p>.....</p> <p>.....</p>

## ХОЁР. ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

2.1	<p>Тухайн албан тушаалд томилогдвол хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ /500-1000 үгэнд багтаана/.</p> <p>Төсвийн тогтвортой байдлыг хангахын тулд парламентийн засаглалтай зарим орнуудын хувьд Төсвийн байнгын хорооныхоо дэргэд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийг (ТТБЗ) байгуулж ажиллуулдаг туршлага байдаг. Энэ жишгийн дагуу Монгол улс хэдэн жилийн өмнө Төсвийн байнгын хорооны дэргэд ТТБЗ-г байгуулсан бөгөөд уг зөвлөлийн гишүүдийг шинээр томилох сонгон шалгаруулалт зарласан байна. Миний бие дараахь хэдэн үндэслэлээр уг сонгон шалгаруулалтанд өөрийн нэрийг дэвшүүлж байна.</p> <p>Нэгдүгээрт, уг зөвлөлийн ажиллах хууль эрх зүйн орчин тодорхой болж, түүний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх судалгааны нэгж Төсвийн байнгын хорооны дэргэд ажиллахаар болсон.</p>
-----	---

Хоёрдугаарт, зөвлөлийн нийт гишүүдийг олон нийтээс ил тод байдлаар сонгон шалгаруулж УИХ-аас томилгооны сонсголоор эцэслэн батлахаар боллоо.

Гуравдугаарт, миний олж авсан боловсрол, банк санхүүгийн салбарт хуримтлуулсан туршлага, хийж байсан төрөл бүрийн судалгааны ажлууд нь зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлагуудыг бүрэн хангаж байгаа бөгөөд доор дэлгэрэнгүй байдлаар өгүүлэе.

Би 1996 онд МУИС-н Математикийн сургуулийг математикийн бакалавр зэрэгтэй, 1998 онд МУИС-ийн Эдийн засгийн дээд сургуулийг банкны бакалавр зэрэгтэй, 2006 онд Японы Засгийн газрын тэтгэлгээр Олон улсын их сургуулийг хөгжлийн эдийн засгийн мастер зэрэгтэйгээр тус тус төгссөн. Монгол улсын банк санхүүгийн салбарт 25 жил ажиллаж байгаа бөгөөд Монголбанкинд банкны хянан шалгагч, Зоос банкинд Дотоод аудитын газрын захирал, Сангийн яаманд Сайдын зөвлөх, Монголбанкинд Санхүүгийн Тогтвортой байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг албуудыг хашиж эдийн засаг, санхүүгийн чиглэлээр тодорхой хэмжээний онолын болон практик мэдлэгийг эзэмшсэн.

Миний бие 2012 онд Сангийн сайдын зөвлөхийн албыг хашсаны дараа эдийн засаг, төсөв санхүү тэр дундаа ЗГ-ын гадаад болон дотоод өрийн талаар холбогдох судалгаануудыг хийж ТВ-үүдэд ярилцлага өгөх, мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл бичих, төрөл бүрийн байгууллагуудад илтгэл тавих, өөрийн судалгааны зарим ажлыг гадаадын цахим сайтад нийтлүүлэх зэрэг ажлуудыг хийсэн байна. Тухайлбал байгалийн баялаг эсвэл экспортын орлого ихтэй улсуудын сайн туршлагад үндэслэн ирээдүй хойч үедээ байгалийн баялгийг өвлүүлэн үлдээх зорилго бүхий Үндэсний баялгийн санг Монголд байгуулах боломжийн талаар судалгаа хийж гадаадын цахим сайтад нийтлүүлж байсан. Тухайн үеийн ЗГ нь гадаадаас төрөл бүрийн чамин нэртэй бондуудыг босгож гадаад өрийг эрс нэмэгдүүлж байсан 2014 онд Нээлттэй нийгэм форумын захиалгаар ЗГ-ын гадаад өрийн чиглэлээр судалгаа хийж тайланг хэвлүүлэн, энэ судалгааны үр дүнгийн талаар олон нийтэд танилцуулга хийж энэ талаар хэд хэдэн ТВ-үүдэд цуврал ярилцлага өгсөн. Түүнчлэн 2017 онд ОУВС, Дэлхийн банк болон ЖАЙКА байгууллагын хамтран Токио хотноо зохион байгуулсан хөгжиж буй орнуудын ЗГ-ын өрийн дунд хугацааны стратегийг боловсруулах семинарт Сангийн яамны төсвийн холбогдох албан тушаалтангуудтай хамт оролцож ЗГ-ын дунд хугацааны өрийн стратегийг боловсруулан СЯ-д хүлээлгэн өгч ЖАЙКА байгууллагад танилцуулсан байдаг. Миний бие 2016-2018 онд Монголбанкинд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ажлын албаны нарийн бичгийн даргаар ажиллаж байх хугацаанд уг албаны судлаач ажилтнуудын хамтаар Монгол улсын санхүүгийн тогтвортой байдлын индикатор үзүүлэлтүүд, тогтолцооны эрсдлийн шинжилгээг хийж, шинжилгээний үр дүнг Монголбанкнаас эрхлэн гаргадаг “Мөнгө.Санхүү.Баялаг” сэтгүүлд хэвлүүлсэн.

Хэрэв миний бие ТТБЗ-н гишүүнээр сонгогдвол ямар ажлуудыг бусад гишүүдийн хамт хийхээр төлөвлөж байгаагаа эрэмбэ дарааллын дагуу тайлбарлахыг хичээе. Нэгдүгээрт, ТТБЗ-н ажиллах олон улсын сайн туршлагыг судална. Энэ туршлагыг судалсны үндсэн дээр зөвлөлийн ажиллах журмыг батлах шаардлагатай. Энэхүү судалгаагаар түүнчлэн зөвлөлийн ажиллах хууль эрх зүйн орчныг цаашид сайжруулахын тулд холбогдох хууль, дүрэм журмуудад ямар өөрчлөлтийг оруулж болохыг тодорхойлно.

Хоёрдугаарт, төрийн бусад байгууллагууд тухайлбал СЯ, Эдийн засгийн хөгжлийн яам, Монголбанк зэрэгтэй зөвлөлийн хамтран ажиллах болон эдийн засаг болон төсөвтэй холбоотой тоон мэдээ мэдээлэл солилцох механизмаа тогтоож авна.

Гуравдугаарт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр уг зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор төсвийн судалгааны нэгж байгуулагдаж ажиллах ёстой. Уг нэгжийн хүний нөөц, боловсон хүчний чадавхи, ажиллах орчныг сайжруулж уг нэгжийг олон улсын түвшинд хүртэл хөгжүүлэхэд Төсвийн байнгын хороотой хамтарч онцгой анхаарч ажиллана.

Дөрөвдүгээрт, төсвийн болон санхүүгийн системийн нэгдсэн дата баазыг хөгжүүлэхэд анхаарах шаардлагатай. Анхан шатны дата бааз сайн байж төсвийн талаарх судалгаа шинжилгээг үр дүнтэй хийх үндэс тавигдана. Одоогийн байдлаар СЯ-н дээр төсвийн мэдээллийн нэгдсэн дата бааз үүсээд хөгжөөд явж байгаа боловч Монголбанкн дээр эхэлсэн санхүүгийн системийн нэгдсэн дата баазыг бий болгох төсөл миний авсан мэдээллээр зогсонги байдалд орсон байна. Энэ төслийг нэн даруй сэргээж үргэлжлүүлэх шаардлагатай. Төсвийн үндсэн дата бааз дээр тулгуурлаж сүүлийн үеийн дата шинжилгээ

	<p>болон хиймэл оюун ухааны арга техникийг ашиглаж дээрхи судалгааны нэгж төрөл бүрийн чухал судалгаануудыг өндөр түвшинд хийх шаардлагатай.</p> <p>Тавдугаарт, зөвлөлийн олон нийттэй харилцах үйл ажиллагаа маш чухал. Зөвлөл нь төсвийн чухал асуудлууд дээр олон нийт болоод УИХ, ЗГ хооронд итгэлцлийн гүүр болж ажиллах учиртай. Олон нийт төсвийн дунд хугацааны мэдэгдэл, тухайн оны төсвийн талаар мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэгдсэн, улс төрөөс хараат бус мэдээ, мэдээллийг зөвлөлөөс авч байвал зохилтой. УИХ-ын гишүүдийн улсын төсвийн талаархи суурь үнэлэмж нь зөвлөлөөс улсын төсвийн талаар гаргаж буй дүгнэлт, зөвлөмжинд түшиглэж байх. Нөгөө талаас ЗГ нь зөвлөлөөс төсвийн талаар гаргаж буй шүүмж дүгнэлтийг өөр дээрээ тусган авч төсвийг засаж сайжруулж байх ёстой. Иймээс зөвлөл нь олон нийттэй харилцах мэдээллийн сувгуудаа тухайлбал сошиал хуудсуудаа сайтар хөгжүүлж түүгээрээ дамжуулан олон нийтэд төсвийн талаарх мэдээ, мэдээллийг тогтмол шуурхай хүргэж байх шаардлагатай.</p> <p>Зургадугаарт, зөвлөл нь төсвийн дараа дараагийн шинэчлэлийн ажлуудад онцгой хувь нэмэр оруулах учиртай. Сая 2023 оны 7 дугаар сард Төсөв болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтүүдээр төсвийн шинэчлэлийн эхний ажил хийгдсэн гэж ойлгож байна. Дараагийн шинэчлэлийн ажил бүхэлдээ татварын шинэчлэлийн ажилд зориулагдах учиртай. Жижиг, дунд компаниудын өсөлт хөгжилт болон компаниас ажилтнуудын цалингийн түвшинг нэмэхэд том чөдөр тушаа болж буй НДШ-н хувь хэмжээг өөрчлөх, улс орны бүсчилсэн хөгжилтэй уялдуулан татварын бодлогыг шинэчлэх гэх мэт татварын талаар хийх зүйлс маш их байна. Цаашлаад тэтгэврийн реформыг олон улсын жишгийн дагуу өөрийн орны онцлогт тохируулан хийх, Үндэсний аудитын газрыг улс төрөөс хараат бусаар ил тод ажиллах нөхцлийг бүрдүүлж ажиллах хууль эрх зүйн орчныг нь сайжруулах, гадаад өрийн дарамтыг ихээр нэмэгдүүлж, хөрөнгө оруулалтын үр ашиг муутай томоохон мега төслүүдэд зориулж авч буй гадаадын зээллэг авах механизмыг шат дараалсан хяналттай болгох гэх зэрэг төсвийн талаар нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх ажлууд байгаа</p> <p>Эцэст нь зөвлөлийн гишүүний ажил үүргийг хийж гүйцэтгэхэд миний өнгөрсөн 25 жилийн хугацаанд Монгол улсын банк санхүүгийн салбарт ажиллаж хуримтлуулсан онолын болон практик мэдлэг, туршлага маань хүрэлцэнэ гэдэгт итгэлтэй байна.</p>
--	--

**Хүсэлт гаргагч:**

Эцэг/эхийн нэр: Лхагважав . . . . .

Өөрийн нэр: . . .Гангэрэл. . . . .

Гарын үсэг: . . . . .

Он, сар, өдөр: 2023/12/06 . . . . .

--- оОо ---

## Хавсралт 1

Эдийн засаг, төсөв, мөнгөний бодлого, санхүү, татварын чиглэлээр өндөр мэдлэг, ур чадвартайг нотлох онцлох 10 үйл ажиллагаа

Д/д	үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа	үйл ажиллагааны гол агуулга	үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ
1	Монгол улсын санхүүгийн тогтвортой байдлын эрсдлийн индикаторуудыг тодорхойлох талаар АХБ-тай хамтарч хийсэн судалгааны үр дүнг Монголбанкны Захирлуудын зөвлөлийн гишүүдэд танилцуулах, Монголбанк, 2017	Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн ажлын албанаас АХБ-тай хамтран Монгол улсын санхүүгийн тогтвортой байдлыг дээшлүүлэх чиглэлээр хамтарсан судалгааны төсөл хэрэгжүүлж, үр дүнг МБ-ын захирлуудын зөвлөлийн гишүүдэд танилцуулах	Хамтарсан судалгааны үр дүнгийн талаар МБ-ны захирлуудын зөвлөлийн гишүүд тодорхой мэдээлэл авч, цаашид энэ эрсдлийн индикаторуудыг тогтмол тооцож байх зөвлөмжийг гаргасан  Нотлох баримт: Хавсралт 8
2	Монгол улсын банк санхүүгийн системд долларжилтын үзэгдэл идэвхтэй явагдаж байгаатай холбоотойгоор долларжилтийн эсрэг ямар шийдвэрүүдийг гаргаж ажиллах боломжтой талаар судалгаа хийж Монголбанкны Захирлуудын зөвлөлийн гишүүдэд танилцуулах, Монголбанк, 2017	Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ажлын албанаас Монгол улсын банк санхүүгийн системд идэвхтэй явагдаж буй долларжилтын үзэгдлийн талаар судалгааг хийж, үр дүнг холбогдох арга хэмжээний хамт МБ-ын захирлуудын зөвлөлийн гишүүдэд танилцуулах	Танилцуулгын үр дүнгээр олон улсын сайн туршлагын дагуу холбогдох макро зохистой бодлогуудыг Монголбанк болон СЯ-аас авч хэрэгжүүлэх бодлогын зөвлөмжүүдийг гаргасан. Тухайлбал: банкууд дахь иргэд, аж ахуйн нэгжүүдийн төгрөгийн дансыг шууд ам долларын данс болгож хөрвүүлэхийг зогсоох, гадаад валютын хадгаламж дээр тавих ЗБНөөцийн хувь хэмжээг нэмэгдүүлэх, иргэд дотооддоо өөрийн валютын данс хооронд гүйлгээ хийхээс бусад тохиолдолд гадаад валютын шилжүүлэг хийхгүй байх гэх мэт.
3	Төсвийн талаарх судалгааны үр дүнг олон нийтэд танилцуулах: Монгол улсын 2015 оны төсвийн шинжилгээ--- гадаад өрийн нөхцөл байдал Нээлттэй Нийгэм форум, 2015 он	ЗГ-аас УИХ-д улсын төсөв өргөн баригдсаны дараа Нээлттэй нийгэм форумаас хөндлөнгийн бие даасан эдийн засагчдаар төсвийн шинжилгээг хийлгэдэг. Энэ үйл ажиллагааны хүрээнд миний бие ЗГ-ын гадаад өрийн нөхцөл байдлын шинжилгээг хийж олон нийтэд танилцуулсан	Судалгаа шинжилгээний үр дүнгээр цаашид ЗГ-аас гадаад өрийн асуудал дээр онцгой анхаарах шаардлагатай байгааг харуулсан.  Нотлох баримт: Хавсралт 7
4	Банк санхүүгийн системд гарч буй томоохон өөрчлөлтүүдийн талаархи илтгэл, ШУТИС-ын харъяа Бизнес, Менежментийн сургууль, 2021	Банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт өөрчлөлт орсонтой холбогдуулан Монголын банк санхүүгийн системд гарах гэж буй томоохон өөрчлөлтүүдийн талаар уг сургуулийн багш, ахлах курсийн оюутнуудад илтгэл тавьсан	Илтгэлийн үр дүн: Системийн ач холбогдолтой банкууд МХБ-ээр дамжуулан олон нийтэд 20 хүртэлх хувиа зарж нээлттэй хувьцаат компани болох, банкууд дор хаяж 5 хувьцаа эзэмшигчтэй болно, энэ бүхэн нь хөрөнгийн захын үйл ажиллагааг маш эрчимжүүлнэ, банкны секторын ил тод байдал сайжрах хүлээлт байна

			Нотлох баримт: Хавсралт 3
5	Монгол улсын 2023 оны макро эдийн засгийн төлөв— Төсөв ба мөнгөний бодлого, Туркт төгсөгч Монгол оюутнуудын холбоо, 2022	Монгол улсын 2023 оны төсөв ба мөнгөний бодлого батлагдсантай холбогдуулан төсөв ба мөнгөний бодлого хэрхэн батлагдав, түүний голлох заалтууд түүнчлэн энэхүү төсөв ба мөнгөний бодлого нь жижиг дунд бизнес эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд хэрхэн нөлөөлөх талаар яриа танилцуулга хийсэн	Танилцуулгын гол үр дүнгүүд: -төсвийг өмнөх жилүүдтэй адилхан өндөр алдагдалтайгаар баталлаа - экспортын зарим ашигт малтмалтын үнийг өндрөөр төсөөлсөн байна -хөрөнгө оруулалтын хувьд сайн тал нь шинээр нэмж хөрөнгө оруулалт тавиагүй өмнөх жилүүдийн хөрөнгө оруулалтуудыг дуусгахаар төлөвлөсөн  Нотлох баримт: Хавсралт 2
6	Төсвийн алдагдлыг бууруулах талаар ТВ ярилцлага, Bloomberg TV, 2018	Ярилцлагын гол санаа нь төсвийн алдагдлыг эрс бууруулахгүй бол мөнгөний бодлогын үр нөлөөг бууруулахын зэрэгцээ санхүүгийн тогтвортой байдалд муугаар нөлөөлж байна.	Ярилцлагын гол үр дүн нь төсвийн алдагдал нь мөнгөний бодлогын үр нөлөөг бууруулж байна, улмаар санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байгааг олон нийтэд мэргэжилтний үүднээс танин мэдүүлэх  Нотлох баримт: Ярилцлагын линк: <a href="https://www.youtube.com/watch?v=FogoNMSIKP0">https://www.youtube.com/watch?v=FogoNMSIKP0</a>
7	ЗГ-ын гадаад өрийн талаар Монгол ТВ-д өгсөн 2 цуврал ярилцлага	Ярилцлагын гол санаа нь ЗГ гадаад өрийн менежмент дээрээ эрс сайжруулалт хийхгүй өрийн дарамт сэрэмжлэх түвшинд ирлээ гэдгийг анхааруулав.	Ярилцлагын гол үр дүн нь ЗГ-ын гадаад өр 2012-2014 оны хооронд маш эрчимтэй өслөө, мөн хувийн хэшлийн гадаад өрийн менежментийг ЗГ болон МБанк хамтарсан зохицуулалт хийх шаардлагатай талаар олон нийтэд мэргэжилтний хувьд хараат бус мэдээлэл өгсөн.  Нотлох баримт:  Ярилцлагуудын линк: Линк 1: <a href="https://youtu.be/05h5QVd6MAU?si=RoUanxTyiwqq9E-K">https://youtu.be/05h5QVd6MAU?si=RoUanxTyiwqq9E-K</a> Линк 2: <a href="https://youtu.be/2hlcA-juXDs?si=Z6NKvS79zyyNx8rR">https://youtu.be/2hlcA-juXDs?si=Z6NKvS79zyyNx8rR</a>
8	Монгол улсад Үндэсний баялгийн санг байгуулах боломжийн талаар олон улсын уншигчдад мэдээлэл өгөх, Bootheglobalperspectives international e-newsletter-д судалгааны хураангуйг нийтлүүлэх	Судалгааны гол санаа нь байгалийн арвин нөөцтэй Монгол улсын хувьд бусад орнуудын сайн жишгийг даган ашигт малтмалын экспортон дээрээ тулгуурлан ирээдүй хойч үедээ байгалийн баялгийн өв сангаа үлдээх, эдийн засгийн хөгжлөө түргэсгэх, гадаад	Судалгааны товч хураангуйг олон улсын цахим newsletter дээр тавьсан бөгөөд олон улсын уншигчид Монгол улсын талаар, энэ улсад баялгийн санг байгуулах боломжтой талаар тодорхой ойлголтыг авсан  Нотлох баримт:

		валютын нөөцийг бий болгохын тулд Үндэсний баялгийн санг байгуулах боломж байна гэдгийг харуулсан	Судалгааны линк: <a href="https://bootheglobalperspectives.com/page?id=1373820260WBG117435235&amp;t=sovereign-wealth-fund-for-mongolia">https://bootheglobalperspectives.com/page?id=1373820260WBG117435235&amp;t=sovereign-wealth-fund-for-mongolia</a>
9	Монгол улсын гадаад өрийн дарамтыг бууруулах талаар хамтарсан судалгааг Дэлхийн банктай хамтарч хийж судалгааны үр дүнг Монголбанкны Захирлуудын зөвлөлийн гишүүдэд танилцуулах, Монголбанк, 2017	Монгол улс нь 2017 онд гадаад өрийн ихээхэн дарамтад орж ОУВСангийн тусгай хөтөлбөрт орж байсан цаг үе бөгөөд үүнтэй холбогдуулан ДБ-ны зөвлөлтэй хамтран гадаад өрийн дарамтыг бууруулах талаар судалгаа хийсэн	Судалгааны гол үр дүн нь төсвийн алдагдлыг эрс бууруулах, төсвийн сахилга батыг сахиж ажиллах, төсөв ба мөнгөний бодлогын хоорондын уялдаа холбоог сайжруулах талаар бодлогын зөвлөмж гаргасан
10	Монгол улсын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийг хийж Сангийн Яаманд хүлээлгэн өгөх, Сангийн яам, 2018	Монголбанк, Сангийн яамны хамтарсан баг ОУВС, Жайкагийн хамтран зохион байгуулсан хөгжиж буй орнуудын дунд хугацааны өрийн удирдлагын стратегийг боловсруулах семинар сургалтанд Япон улсад 14 хоног суусан. Энэхүү семинарын үр дүнгээр Монгол улсын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн төслийг боловсруулсан	Стратеги боловсруулах төслийн үр дүнгээр Монгол улс төсвийн сахилга батыг дээд зэргээр чандлан сахиж, төсвийн алдагдлыг эрс бууруулах, бонд болон хөрөнгө оруулалт хэлбэрээр гадаадаас авч буй хөрөнгүүдийн зарцуулалтын үр ашгийг эрс дээшлүүлэх шаардлагатай болох нь батлагдсан. Уг стратегийг холбогдох тооцоо судалгааны хамт Сангийн яаманд хүлээлгэн өгсөн. Мөн Монголд ирсний дараа семинарын баг Жайка байгууллагад стратегийн төслийг танилцуулсан.